

БАТЛАВ
ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ЯАМНЫ ТӨРИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Л.МӨНХЗУЛ
Улаанбаатар хот

2025 оны сарын ... –ний өдөр

**ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН (144 ДҮГЭЭР ЗҮЙЛИЙН 144.2 ДАХЬ ХЭСЭГ)
ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГУУЛАХАД ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭН, ТӨРИЙН БУС
БАЙГУУЛЛАГЫН ОРОЛЦОО, ХАМТРАН ХЯНАЛТ ТАВИХ АРГАЧЛАЛ, ТӨЛӨВЛӨГӨӨ
БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР**

АЖЛЫН ЗОРИЛГО: Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн 144.2 дахь хэсгийн хэрэгжилтийг хангуулахад хөгжлийн бэрхшээлтэй иргэн, төрийн бус байгууллагын оролцоо, хамтран хяналт тавих аргачлал, төлөвлөгөө боловсруулж хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэхэд оршино.

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА:

Эхлэх хугацаа: 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдөр

Дуусах хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдөр

НЭГ.ҮНДЭСЛЭЛ

Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн 144.2 дахь хэсэгт зааснаар өмчийн төрөл, хэлбэрээс үл хамаарч 25 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нь нийт ажлын байрныхаа дөрвөн хувиас доошгүй орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулах үүрэгтэй. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд ажил олгогч байгууллагуудын оролцоо чухал байдаг.

Монгол Улсад 2024 оны байдлаар нийт 107.9 мянган хөгжлийн бэрхшээлтэй иргэн бүртгэгдсэнээс 87.3 мянга нь хөдөлмөрийн насны хүн байна. Эдгээр иргэдийн 15 хувь буюу 16.2 мянган хүн хөдөлмөр эрхэлж байгаа хангалтгүй үзүүлэлт юм.

Иймд дээрх хуулийн заалтын хэрэгжилтэд хяналт шалгалт хийх, хуулийн хэрэгжилтийг хангуулах замаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт нэмэгдэх, байнгын ажлын байраар хангах шаардлага байна.

ХОЁР. АЖЛЫН ЦАР ХҮРЭЭ

Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн 144.2 дахь хэсгийн хэрэгжилтийг хангуулахад хөгжлийн бэрхшээлтэй иргэн, төрийн бус байгууллагын оролцоо, хамтран хяналт тавих аргачлал, төлөвлөгөө боловсруулж ажлыг гүйцэтгэнэ.

ГУРАВ. ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ

Багцад тусгагдсан ажлын тоо, төсөл, арга хэмжээ бүрээр дараах ажлыг гүйцэтгэнэ. Үүнд:

№	Гүйцэтгэх ажил	Агуулга	Зардал (мян.төг)	Хугацаа
	Хэрэгжилтийг хангуулах оролцоо	- Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн 144.2 дахь хэсгийн хэрэгжилтийн сүүлийн 2 жилийн байдлаар - Хуулийн хэрэгжилтийг хангуулахад хөгжлийн бэрхшээлтэй иргэн, төрийн бус байгууллагын оролцоо хэр байсан талаар - Цаашид хэрэгжилтэд хөгжлийн бэрхшээлтэй иргэн, төрийн бус байгууллагын оролцоо хэрхэн хангах санал	1,000.0	XI/01-XI/10
	Хяналт тавих аргачлал	- Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн 144.2 дахь хэсгийн хэрэгжилтэд хөгжлийн бэрхшээлтэй иргэн, төрийн бус байгууллагатай хамтран хяналт тавих боломж нөхцөл, үр дүн - Хяналт тавих аргачлалд хөгжлийн бэрхшээлтэй иргэн, төрийн бус байгууллагын үүрэг, оролцоог нарийвчлан тусгана.	3,000.0	XI/12-XI/25
	Ажлын төлөвлөгөө	2026 онд Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн 144.2 дахь хэсгийн хэрэгжилтийг хангуулах, хяналт хийх	1,000.0	XI/26-XI/30
	Аргачлал, төлөвлөгөө танилцуулах хэлэлцүүлэг	Хөдөлмөрийн тухай хуулийн (144 дүгээр зүйлийн 144.2 дахь хэсэг) хэрэгжилтийг хангуулахад хөгжлийн бэрхшээлтэй иргэн, төрийн бус байгууллагын оролцоо, хамтран хяналт тавих аргачлал, төлөвлөгөөний төсөл танилцуулан хэлэлцүүлэх		XII/01-XII/07
	Эцсийн тайлан ирүүлэх	Тайлан, 3 бүтээгдэхүүн цаасаар болон файлаар		XII/15

ДӨРӨВ.ГҮЙЦЭТГЭГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Гүйцэтгэгч нь баг, хувь хүн байж болно.

Туршлага:	Ур чадвар:
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр ажилласан туршлагатай байх; - Судалгаа, мониторинг, удирдамж боловсруулах чиглэлээр ажиллаж байсан туршлагатай байх; - Өмнө нь ижил төстэй ажил хийж гүйцэтгэж байсан бол давуу тал болно; - Хөгжлийн бэрхшээлтэй иргэн байна.	- Баримт бичиг боловсруулах ур чадвартай; - Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн талаар мэдлэгтэй байх; - Мэдээлэл боловсруулах, судалгаа дүн шинжилгээ хийх, баримт бичиг боловсруулах чадвартай байх.

ТАВ.ХЯНАЛТ, ТАЙЛАГНАЛТ

Тус яамны Гэр бүлийн бодлогын газар, хэлтсийн дарга, холбогдох мэргэжилтэн үйл ажиллагаанд хяналт тавина.

ЗУРГАА.САНХҮҮЖИЛТ, ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжил хамгааллын чиглэлээр туссан хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх үйлчилгээ зардлаас санхүүжүүлнэ. Арга хэмжээний төлбөр нь 5,000,000 (таван сая) төгрөг байна.

Төлбөрийг Монгол төгрөгөөр олгох бөгөөд төлбөрт бүх зардал, татвар, хураамж багтсан болно.

ДОЛОО.БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ

- Ажил гүйцэтгэгчийн анкет
- Иргэний үнэмлэхийн хуулбар;
- Диплом болон холбогдох гэрчилгээний хуулбар;
- Туршлагыг нотлох сургалт арга хэмжээний танилцуулга;
- Албан хүсэлт;
- Ур чадварыг үнэлэх нэмэлт баримт бичиг.

---oOo---